



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/74

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоол “Сумын 2020 оны төсөв батлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Суманд 2020 оны Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх “Хог тээвэрлэх автомашин худалдан авах”-д зарцуулагдах 66980000 /жаран зургаан сая есөн зуун наян мянга/ төгрөгийг зарцуулсугай.

2. “Хог тээвэрлэх автомашин худалдан авах” ажилд зарцуулагдах 66980000 /жаран зургаан сая есөн зуун наян мянга/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.

3. Дээрх ажилд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ